

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 11-р сарын 23

Тендер шалгаруулалтын нэр: “Монголросцветмет” ХХК-д “Төв ус зайлуулах байгууламж+1110 м. (Далд уурхайн зориулалттай цахилгаан хуваарилах төхөөрөмж КРУРН-6LE 200А)” нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦТ/201803002

“Монголросцветмет” ХХК эрх бүхий тендерт оролцогчдоос “Төв ус зайлуулах байгууламж+1110 м. (Далд уурхайн зориулалттай цахилгаан хуваарилах төхөөрөмж КРУРН-6LE 200А)” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2016, 2017 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна*

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *2016, 2017 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан байх ба дүгнэлтийн хамт ирүүлэх.*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагагүй**

Тендерийн хамт **1 900,000.00** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 12 дүгээр сарын 23-ны өдрийн 14:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба **мөн өдрийн 14:10 цагт** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 409 тоот өрөө, утас: 450060 + 188